



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



Empowered lives.
Resilient nations.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлаг

**“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь”
төсөл**

2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2018 оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31

2018 оны 12 дугаар сар
Улаанбаатар хот

ТӨСЛИЙН ТУХАЙ

Тайлан хамарч буй хугацаа:	2018 оны 1 дүгээр сарын 1 - 12 дугаар сарын 31
Төслийн дугаар	МОН/17/101
Төслийн нэр:	“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь”
Төсөл хэрэгжиж эхэлсэн огноо:	2017 оны 1 дүгээр сарын 01
Төсөл хэрэгжиж дуусах огноо:	2020 оны 12 дугаар сарын 31
Хэрэгжүүлэгч:	Улсын Их Хурлын Тамгын газар
Төслийн талууд:	Монгол Улс дахь НҮБХХ, УИХ-ын Тамгын газар
Төслийн төсөв (нийт):	3,800,000 ам.доллар
Санхүүжилт:	ШХА 3,300,000 ам.дол НҮБХХ 500,000 ам.дол
НҮБХТХ, НҮБХХ-ийн улс орны хөтөлбөрийн холбогдох үр дүн: 2021 гэхэд засаглалын байгууллагууд залуучуудын үр нөлөөтэй оролцоог хангаж, ядуу, эмзэг бүлгийн эрхийг хамгаалан, иргэдийн өмнө хүлээх хариуцлага дээшилнэ. Төслийн хүлээгдэж буй үр дүн: 1. Нутгийн удирдлагын эрх зүйн орчин сайжирсан байна. 2. ИТХ-ын зохион байгуулалтын чадавх сайжирсан байна. 3. Сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизм бий болсон байна. 4. УИХ-ын Тамгын газраас төлөөллийн байгууллагад дэмжлэг үзүүлэх чадавх дээшилсэн байна.	
2018 оны төсөв	1.200.000 доллар
2018 оны төсвийн гүйцэтгэл (12 сарын 31-ний байдлаар)	889,236
Гүйцэтгэл %	73,8%

АГУУЛГА

ОРШИЛ	4
Үгийн товчлол	6
I ХЭСЭГ: ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ҮР ДҮН:	7
ХҮРЭХ ҮР ДҮН 1: Нутгийн удирдлагын эрх зүйн орчин сайжирсан байх	7
ХҮРЭХ ҮР ДҮН 2: ИТХ-ын зохион байгуулалтын чадавх сайжирсан байх	7
ХҮРЭХ ҮР ДҮН 3: Орон нутгийн сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизмтай болох:	13
ХҮРЭХ ҮР ДҮН 4: Сонгогдсон Төлөөлөгчдөд дэмжлэг үзүүлэх УИХ-ын Тамгын газрын чадавх сайжирсан байх	15
ДҮГНЭЛТ	16
II ХЭСЭГ: ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:	17
ХҮРЭХ ҮР ДҮН 1: Нутгийн удирдлагын эрх зүйн орчин сайжирсан байх	17
ХҮРЭХ ҮР ДҮН 2: ИТХ-ын зохион байгуулалтын чадавх сайжирсан байх	18
ХҮРЭХ ҮР ДҮН ГУРАВ: Орон нутгийн сонгогдсон Төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизмтай болох	21
ХҮРЭХ ҮР ДҮН 4: Сонгогдсон Төлөөлөгчдөд дэмжлэг үзүүлэх УИХ-ын Тамгын газрын чадавх сайжирсан байх	29
Хавсралт	35

ОРШИЛ

“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөл нь хоёр дахь жилдээ хэрэгжиж байна. Төсөл 2018 онд Хүрэх үр дүн тус бүрт тодорхой ахиц гаргалаа.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн дүн шинжилгээ, нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал бэлэн болж, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Төвлөрлийг сааруулах эрх зүйн орчныг судалж, санал дүгнэлт гаргах Ажлын хэсэгт танилцуулагдав. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэх чиг үүрэг бүхий УИХ-ын Ажлын хэсгийн гишүүд хотын эрх зүйн байдал, орон нутгийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх субъектыг сонгох болон томилох асуудал, орон нутгийн өмчийн удирдлага, татварын чиглэлээр бусад улс орны туршлагыг судалж, мэдээллийг Ажлын хэсгийн хэлэлцүүлгийн үеэр танилцууллаа.

Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын бүрэлдэхүүнтэй зургаан ажлын хэсэг жишиг дэгийг нэвтрүүлэх, гүйцэтгэлийн багц үзүүлэлтийг боловсруулах, ажлын албыг чадавхжуулах сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөө гаргах зэрэг чиглэлээр байгуулагдан ажиллаж, төслийн хүрээнд бий болсон үр дүнг бэхжүүлэх, тогтвортой хадгалан авч үлдэхэд хувь нэмрээ оруулж байна. ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын уулзалт, семинарыг хэд хэдэн удаа зохион байгуулсан нь тэдний чадавхыг сайжруулах, идэвх оролцоог нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

ИТХ-ын сайн туршлагыг хөхиүлэн дэмжих зорилготой тэтгэлэгт хөтөлбөрт 2018 онд 38 ИТХ-ын санал шалгаран хэрэгжүүлэв. Энэ удаагийн тэтгэлэгт хөтөлбөрийн онцлог нь хурлын хяналт, төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэх санал санаачлагыг дэмжихийн зэрэгцээ ШХА-ын “Ногоон алт” төсөлтэй хамтран бэлчээрийн менежементийн чиглэлээр боловсруулж ирүүлсэн 19 төсөлд тэтгэлэг олгов. Түүнчлэн өмнөх онуудад тэтгэлэг хэрэгжүүлсэн ИТХ-ууд харилцан туршлага солилцох уулзалт зохион байгуулснаар 2018 онд зарлагдсан тэтгэлэгт хөтөлбөрт ирүүлж буй саналууд сайжирсан тохиолдлууд ажиглагдлаа.

Дүүрэг, сумын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтыг зохион байгуулснаар тэдний манлайлах ур чадвар дээшилж байгааг хурлын төлөөлөгчид, ажлын алба онцолж байна. Тус сургалтын гол онцлог нь төлөөлөгч өөрийн хүрээндээ өөрчлөлт бий болгох тодорхой стратегитай ажиллах, үүнийгээ үр нөлөөтэйгөөр хэрэгжүүлэхэд нь шинэ сэдэл, аргачлал өгч чадсан явдал байв.

Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтын хөтөлбөр, агуулга өмнөхөөсөө бүрэн шинэчлэгдэв. Нийт аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдөд зориулан сургалт зохион байгуулснаар тойргийн сонгогчидтойгоо илүү ойр ажиллах, оролцооны чиглэлийн хууль тогтоомжийг үр дүнтэй ашиглах, орон нутагт тулгамдсан асуудлыг тодорхойлох, шийдлийг олох, эдгээр зорилгын үүднээс бие биенээ дэмжиж хамтран ажиллах сэдэл, чадварыг олж авлаа гэж сургалтыг үнэлж байна.

Төлөөлөгчдийн суурь сургалтаар олж авсан мэдлэгийг бататгах сургалт болон сэдэвчилсэн сургалтын агуулгыг шинээр боловсруулж, чадвар, хандлагыг өөрчлөх зорилгоор орон нутгийн төсвийг хэлэлцэхээс өмнөх цаг үед дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөд хүргэв.

Төслийн сургагч багш нарын үүрэг оролцоо сургалтад багшилснаар хязгаарлагдахгүй юм. Зарим сургагч багш нар төслийн хүрээнд зохион байгуулагдсан сургалтуудын үр дүнг үнэлэх, сургалтаар олж авсан мэдлэгээ амьдралд хэрэгжүүлэх, жишиг баримт бичиг, аргачлалыг ИТХ-д нэвтрүүлэх, сайн туршлага бий болгож түгээхэд мэдлэг чадвараа дайчлан, сайн дурын үндсэн дээр сум, багийн хурлуудыг чадавхжуулж ажиллалаа.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын холбооны улсын парламентын Тамгын газартай харилцан туршлага солилцож, Швейцарын холбооны улсын парламентын Тамгын газрын ашигладаг арга зүйн дагуу “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ, шинжилгээ хийх замаар хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх чадавхаа сайжруулж байна.

Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох ажиллагааны журмыг үр нөлөөтэй, хариуцлагатай болгох, улмаар парламентын бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон зарим улсын парламентын хуралдааны дэгийн харьцуулсан шинжилгээ хийж, хуульд тусгах шаардлагатай асуудлууд буюу санал болгох зохицуулалтуудыг тодорхойлов.

Улсын Их Хурлын Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх чиглэлээр хуулийн зөвлөх болон хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажилладаг бусад ажилтнуудад зориулсан гарын авлага, сургалтын хөтөлбөр боловсруулж байна. Тус сургалтын хөтөлбөр, агуулга нь хуулийн төсөл боловсруулах, нийтийн сонсгол зохион байгуулах, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд нь парламентад мэргэжлийн туслалцаа үзүүлэх Тамгын газрын ажилтнуудын мэдлэгийн бүтээгдэхүүн, байнга хэрэглэгдэх эх сурвалж болох юм.

Үгийн товчлол

УИХ	Улсын Их Хурал
ТББХ	Төрийн байгуулалтын байнгын хороо
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗЗНДНТУТХ	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
НӨУБ	Нутгийн өөрөө удирдах байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ТББ	Төрийн бус байгууллага

I ХЭСЭГ: ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ҮР ДҮН:

ХҮРЭХ ҮР ДҮН 1: Нутгийн удирдлагын эрх зүйн орчин сайжирсан байх

Энэ онд нутгийн удирдлагатай холбоотой хууль, эрх зүйн шинэчлэлд томоохон хувь нэмэр болох судалгаа, мэдээллийг төслийн хүрээнд бий болголоо. Нутгийн удирдлагын эрх зүйн шинэчлэлийн асуудлаар УИХ-ын Ажлын хэсгийн гишүүдтэй хамтын ажиллагааг эхлүүллээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн дүн шинжилгээ, нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал бэлэн болж, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Төвлөрлийг сааруулах эрх зүйн орчныг судалж, санал дүгнэлт гаргах Ажлын хэсэгт болон орон нутгийн төлөөлөлд танилцуулагдав. Тус дүн шинжилгээ, санал зөвлөмжийн үндсэн дээр Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэ төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлж байна.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэх чиг үүрэг бүхий УИХ-ын Ажлын хэсгийн гишүүд хотын эрх зүйн байдал, орон нутгийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх субъектыг сонгох болон томилох асуудал, орон нутгийн өмчийн удирдлага, татварын чиглэлээр бусад улс орны туршлагыг судалж, мэдээллийг Ажлын хэсгийн хэлэлцүүлэгт танилцуулж, хамтран ажиллаж байна.

ИТХ-ын үйл ажиллагааг бэхжүүлэх сайн туршлагаас суралцах зорилгоор аймгийн ИТХ-ын дарга нар хөгжиж буй орны /Филиппин, Польш/ нутгийн удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, орон нутгийн бодлого төлөвлөлт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд нутгийн удирдлагын байгууллагаас тавих хяналтын талаар туршлага судалж, шинэ хуулийн үзэл баримтлалд эдгээр улс орны сайн туршлагаас тусгах саналыг боловсруулж байна.

ХҮРЭХ ҮР ДҮН 2: ИТХ-ын зохион байгуулалтын чадавх сайжирсан байх

➤ ИТХ-ын хяналт, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэх сайн туршлагыг хөхиүлэн дэмжих тэтгэлэгт хөтөлбөр

❖ ИТХ-ын тэтгэлэгт хөтөлбөр:

ИТХ-ууд дангаараа болон төрийн бус байгууллагатай хамтран тэтгэлэг хэрэгжүүлэх замаар үйл ажиллагаагаа боловсронгуй болгох, шинэлэг арга барил турших, төлөвлөлт, хяналтад иргэдийг оролцуулах санал, санаачилгууд гарган ажиллав. /Хавсралт 1/

Энэ онд ИТХ-д олгосон тэтгэлэгт үйл ажиллагааны хүрээнд хяналт, төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх, орон нутгийн түвшинд шийдвэр гаргах явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд тодорхой үр дүнтэй ажил хийгдэж, ялангуяа ИТХ-ын хяналтын чиг үүргийг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх чиглэлээр олон ИТХ-ын үйл ажиллагаанд ахиц гарлаа. Тухайлбал:

- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд; */Баян-Өлгий аймаг, Баянхонгор аймгийн Богд сум, Дорноговь аймгийн Айраг сум, Ховд аймгийн Жаргалант сумын ИТХ/*
- Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд; */Дундговь аймгийн Өндөршил сум, Адаацаг сумдын ИТХ, Ховд аймгийн ИТХ, Увс аймгийн Ховд сум /*
- Газрын талаар баримтлах бодлого, шийдвэрт; */Төв аймгийн Алтанбулаг сум/*
- Эрүүл мэндийн талаарх бодлого, хөтөлбөрүүдэд; */Дорноговь аймаг/*
- Байгууллагуудын түлш халаалтын зардалд; */Говь-Алтай аймгийн Шарга суманд/*
- Орон нутагт хэрэгжиж буй тендерийн худалдан авалт, нийлүүлэлтэд */Баянхонгор аймгийн Гурванбулаг сум/* тус тус иргэдийн оролцоотой хяналт хэрэгжүүлж, аргачлал, журам боловсруулан батлуулах, хяналтын зөвлөл байгуулан, гишүүдийг нь чадавхжуулах замаар үр дүн нь хадгалагдан үлдэх нөхцлийг бүрдүүлжээ.


Иргэдийн оролцооны чиглэлээр орон нутгийн шийдвэр гаргах бүхий л түвшинд зорилтот бүлгийн оролцоог нэмэгдүүлэх алхам хийгджээ. Тухайлбал:

- аймгийн ИТХ-ын шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Залуучуудын зөвлөл байгуулагдаж */Баянхонгор аймаг/*,
- сумын ИТХ-ын дэргэд “Эмэгтэйчүүдийн уулзалтын цаг”-тай болж, дэд хөтөлбөр батлагдаж */Хөвсгөл, Эрдэнэбулган/*
- багийн иргэдийн Нийтийн Хуралд малчин эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж, “Эмэгтэйчүүдийн хөгжил” дэд хөтөлбөр */Хөвсгөл, Цагаан-Уул/* боловсруулжээ.

ИТХ-ын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд гарсан зарим үр дүнгээс дурдвал:

Хяналтын чиглэлээр: Төв аймгийн Алтанбулаг сумын ИТХ-ын Хөдөө аж ахуй, байгаль орчин, газрын бодлогын хорооны гишүүд болон багийн ИТХ-ын дарга нар хамтран ажиллах төлөвлөгөө гарган Сумын газрын талаар баримтлах бодлогын хэрэгжилт, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн зураглал, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн явц зэрэгт хяналт шинжилгээ, үнэлгээ хийжээ. 2018 оны 8 дугаар сарын 8-22-ны өдөр хүртэл хугацаанд 4 багийн ИТХ 5 удаа хуралдаж, 366 малчин өрх оролцож, өвөлжөө, хаваржааны эзэмшлийн асуудлаас болж маргаан их гардаг, сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн тусгай зөвшөөрлийг цуцлах зэрэг асуудлыг хэлэлцжээ. Сумын ИТХ-аас сумын нутаг дахь уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд болон сумын газрын талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд иргэдийн оролцоотой хяналт шалгалт хийж, хуралдаандаа танилцуулсан байна. Сумын ИТХ-ын хуралдаанаар “сумын газар нутагт 2025 оныг


хүртэл шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгохгүй байх” шийдвэр гарч, багуудын хилийн заагийг хэлэлцэн баталжээ.

		
Алтанбулаг сумын ИТХ-ын тогтоол "Багуудын хооронд хилийн заагийг баталгаажуулах тухай" 2018.10.24 №05	Багийн ИНХ-ын хуралдаан.....	Алтанбулаг сумын ИТХ-ын тогтоол "Уул уурхайн тусгай зөвшөөрлийн тухай" 2018.10.24 №03

Төслийн санхүүжилтээр зохион байгуулсан ажил нь үр дүнтэй болж, сум орон нутгийн өмнө тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэсэн, иргэдэд үр өгөөжтэй мэдээлэл өгсөн, иргэдийнхээ санал хүсэлтийг хүлээн авч гаргасан шийдвэр хэрэгжих бүрэн боломжтой, иргэдийн санаа бодолд нийцсэн шийдвэр гардаг юм гэдгийг харууллаа гэж сумын ИТХ-аас дүгнэсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын ИТХ-ын тэтгэлэг хэрэгжүүлсэн явцын тайлангаас..

Иргэдийн оролцооны чиглэлээр: Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ИТХ нь “Багийн ИНХ-д эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх” санал гаргаж хэрэгжүүлэв. Тус сумын хүн амын 31,7 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг бөгөөд багийн ИНХ-д оролцогчдын 20 хүрэхгүй хувь нь эмэгтэйчүүд байдаг байна. Иймээс саахалт айл, гудамж хорооллоор нь аравтын бүлэг үүсгэн, 70 эмэгтэйг Аравтын зохион байгуулагч болгон, хурлын зар хүргэх болжээ. Эдгээр арга хэмжээнээс хойш гурван багийн ИНХ хуралдсан бөгөөд эмэгтэйчүүдийн ирц 39.5 хувьд хүрч нэмэгджээ.



Эмэгтэйчүүдийн танилцах цаг, сургалт, бүлгийн ярилцлага зохион байгуулж, тэднийг багийн ИНХ-д үг хэлэх, өөрийгөө илэрхийлэх чадварт болон хэрхэн хамтаараа манлайлах аргад сургасан байна. Баг бүр тулгамдсан асуудлаа тодорхойлон, байгаль орчинг хамгаалах, мод бэлтгэлийн хяналтыг сайжруулах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хүмүүжлийн асуудал зэргийг Хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.



Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум, Шарга баг




Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум, Хужирт баг



Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум, Өвгөд баг

Тэтгэлэгт хамрагдсан болон хамрагдаагүй ИТХ-уудын дунд 2018 оны 11 дүгээр сард төслийн нэгжээс хийсэн түүвэр судалгаанаас харахад ихэнх ИТХ *тус тэтгэлэгт арга хэмжээ нь ач холбогдолтой /68 хувь/ бөгөөд тэтгэлэгийн үр дүнд бий болсон сайн туршлагаас суралцаж, үйл ажиллагаандаа нэвтрүүлдэг* гэж хариулжээ.



Бэлчээрийн менежментийн чиглэлээр: Энэ удаагийн тэтгэлэгт хөтөлбөрийн нэг онцлог нь Швейцарын хөгжлийн агентлагийн төслүүдийн хамтын ажиллагааны хүрээнд “Ногоон алт” төсөлтэй хамтран бэлчээрийн менежментийн чиглэлээр боловсруулсан 19 ИТХ-ын саналд тэтгэлэг олгосон. Энэ чиглэлээр хэрэгжүүлсэн тэтгэлэгийн хүрээнд гарсан зарим үр дүнгээс дурдвал:

- Төв аймгийн Өндөрширээт сумын ИТХ малчдын өрхүүдэд бэлчээрийн даацыг зохицуулах журам, бэлчээр ашиглах гэрээний талаар танилцуулж, эрсдлийн сан байгуулах талаар санал авахад малчин өрхийн 80 хувь нь зөвшөөрсөн байна.
- Булган амийн Хутаг-Өндөр сумын ИТХ-ын тогтоолоор Тээл багийн бэлчээр ашиглалтын журмыг баталжээ.

- Дундговь аймгийн Хулд сумын малчин өрх 449, мал бүхий 186 өрх Бэлчээр ашиглагчдын холбоонд элсэж, дундын хураимтлалын сантай болсон байна.
- ❖ Төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр

Энэ онд зургаан ТББ тэтгэлэг хэрэгжүүлж буй бөгөөд 1 аймаг, 2 дүүрэг, 6 сумын ИТХ, болон баг, хорооны ИНХ тэдгээртэй хамтран ажиллав. Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын төсвийн хяналтын чиг үүргийг иргэдийн оролцоотой хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалахад иргэдийн оролцооны тогтвортой механизмыг бий болгох, нийтийн сонсголд суралцах зэрэг чиглэлээр тодорхой ажлууд хийгдлээ. Тухайлбал,

- Дархан-Уул аймгийн Дархан суманд нийтийн сонсголыг анх удаа зохион байгуулав.
- Сүхбаатар дүүргийн зарим хороодод төсвийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр Иргэдийн хяналтын бүлгүүд байгуулагдав.
- Дорнод аймгийн Хөлөнбуйр сум, нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХ Бодлогын үнэлгээ хийх аргачлалд суралцав.
- Завхан аймгийн Улиастай сумын ИТХ байгаль орчныг хамгаалах чиглэлээр иргэдийн оролцоог хангах журам боловсруулж байна.
- Төв аймгийн Баян, Сэргэлэн, Алтанбулаг сумд уул уурхайн салбар дахь хяналтын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай аргачлал, удирдамжийг боловсруулж байна.


➤ **ИТХ-ын үйл ажиллагаанд хэрэглэх аргачлал, гарын авлага боловсруулж, нэвтрүүлэх:**

ИТХ-ын хуралдааны жишиг дэгийг нэвтрүүлэх, гүйцэтгэлийн багц үзүүлэлтийг боловсруулах, ажлын албыг чадавхжуулах сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөө гаргах зэрэг чиглэлд аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нараас бүрдсэн ажлын хэсэг идэвх санаачлагатай ажиллаж байна.

ИТХ-ын хуралдааны жишиг дэгийг зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулсан бөгөөд нарийн бичгийн дарга нараас бүрдсэн ажлын хэсэг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын уулзалт, сургагч багш нарын сургалтын үеэр хэлэлцүүлэн, тэдний саналыг авч тусган нэмэлт боловсруулалт хийв. Аймаг, сум, дүүргийн ИТХ-д тус үлгэрчилсэн дэгийг нэвтрүүлэх талаар судлан үзэхийг хүссэн албан бичгийг хүргүүлээд байна. Үүний үр дүнд аймаг, сумын ИТХ-ууд жишиг дэгийг өөрийн одоогийн мөрдөж буй хуралдааны дэгтэй харьцуулан судалж, шинэчлэн баталж эхлээд байна.

ИТХ-ын ажлын үр дүнг үнэлэх багц үзүүлэлтийн төслийг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж буй нарийн бичгийн дарга нарын Ажлын хэсэг 5 дугаар сард Улаанбаатар хотод уулзаж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох орчин үеийн чиг хандлага, Европын орнуудад хэрэгжүүлж буй туршлага, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, мэдээлэл цуглуулах талаар мэдээлэл сонсож, тодорхой ойлголттой болсон.

Төслийн нэгжээс хийсэн түүвэр судалгаанаас харахад ИТХ ажлаа хаана, ямар давтамжтайгаар, хэрхэн тайлагнах тогтсон механизм одоогоор бүрэлдээгүй байгаа юм.




Зөвлөх үйлчилгээний хүрээнд ИТХ-ын гүйцэтгэлтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн загвар гаргаж, дээрх асуудлын шийдлийг тодорхойлох бөгөөд, эхний загвар хувилбарыг Ажлын хэсгийн гишүүд өөрийн ИТХ-д туршин үзэв.

➤ www.khural.mn цахим хуудас

Бүх шатны ИТХ-ын www.khural.mn цахим хуудаст дүн шинжилгээ, мониторинг хийж, сайжруулах санал боловсруулах чиглэлээр ажиллаж буй нарийн бичгийн дарга нарын ажлын хэсгийн гишүүд аймаг, сум, дүүргийн дэд цахим хуудсуудад дүн шинжилгээ, мониторинг хийж, цахим хуудасны хөтлөлт хөгжүүлэлт агуулгын болон техникийн одоогийн түвшин, цаашид хэрхэн сайжруулж болох талаар санал боловсруулсан. Зөвлөх үйлчилгээний хүрээнд цахим хуудсыг сайжруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох ажил хийгдэв. Зөвлөхийн боловсруулсан санал дүгнэлтэд үндэслэн цахим хуудсыг шинэчлэн сайжруулах ажил ирэх онд хийгдэнэ. ЗГХЭГ-ын Мэдээллийн технологийн хэлтэс 2017 оноос тус цахим хуудсыг хариуцан ажиллаж байна.

Төслийн нэгжээс хийсэн түүвэр судалгаанаас харахад аймаг, сум, дүүргийн ИТХ-ууд www.khural.mn цахим хуудаст төсөвтэй холбоотой мэдээ мэдээлэлд илүү анхаарч, нийтэлдэг байна. Нийт аймгийн ИТХ-ын 61.9 хувь нь энэ талаарх мэдээллийг бүгдийг нийтэлдэг бол 38.1 хувь нь заримыг буюу ихэнхийг нийтэлдэг гэжээ. Харин судалгаанд оролцсон сумын ИТХ-ын 30 хувь нь энэ талаар мэдээллийг бүгдийг нийтэлдэг, 36.6 хувь заримыг буюу ихэнхийг нийтэлдэг гэсэн байна.



Харин судалгаанд хамрагдсан аймгийн ИТХ-ын 38 хувь, сумын 60 гаруй хувь нь хуралдааны тэмдэглэлийг огт нийтэлдэггүй гэснээс харахад ИТХ-уудын төсвийн ил тод байдал сайн ч хурлын дотоод үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэл хүргэхэд төдийлөн анхаарал хандуулдаггүй гэж харагдаж байна. Нөгөө талаар сумдын ИТХ-ын ажлын албаны хүний цөөц болон техникийн чадавхтай холбоотой байж болох юм.

ХҮРЭХ ҮР ДҮН 3. Орон нутгийн сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизмтай болох:

➤ ИТХ-ын Төлөөлөгчдөд зориулсан сургалт

Бүх шатны ИТХ-ын төлөөлөгчид хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай мэдлэг, ур чадварыг Тэргүүлэгчийн манлайллын сургалт, эмэгтэй Төлөөлөгчдийн манлайллын сургалт, дүүргийн төлөөлөгчдөд зориулсан бататгах сургалтын хүрээнд олж авав.

Удирдлагын академигаар 2017 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах суурь сургалтын хөтөлбөр, агуулгыг Удирдлагын академи боловсруулахаар хариуцан авсан. Энэ хүрээнд 2018 онд сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах хэрэгцээний судалгаа хийгдэж, бататгах болон сэдэвчилсэн сургалтын агуулгыг боловсруулсан.

Төлөөлөгчдийн суурь сургалтаар олгогдсон мэдлэгийг практикт хэрэгжүүлж, бататгах сургалтын хөтөлбөрийг: ИТХ-ын шийдвэр, шийдвэр гаргах үйл явц; Хууль тогтоомжийн хэрэглээ; Орон нутгийн төсвийг төлөвлөх, хянахад ИТХ-ын гүйцэтгэх үүрэг; Байгаль хамгаалал, газрын харилцаа-ИТХ болон иргэдийн оролцоо гэсэн үндсэн гурван сэдвээр боловсруулсан. Энэхүү ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан бататгах сургалтын агуулгаар сургагч багш нарыг мэргэшүүлэх буюу давтан сургалтыг 6 сарын 12,13-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Тус бататгах сургалтын “Орон нутгийн төсвийг төлөвлөх, хянахад ИТХ-ын гүйцэтгэх үүрэг” сэдвийн агуулгыг дүүргийн ИТХ-ын Төлөөлөгчдөд хүргэх сургалтыг 11 дүгээр сард зохион байгуулсан нь ИТХ-аар орон нутгийн төсөв хэлэлцэхийн өмнө болж байгаагаараа цаг хугацааны хувьд ач холбогдолтой юм. /Хавсралт 2/

Сургалтын үеэр хийсэн судалгааны дүнгээс харахад оролцогчдын 94,3 хувь нь “энэ сургалтад хамрагдсанаар төсөв хэлэлцэх явцад эерэг өөрчлөлт гарна” гэсэн бол 81,2 хувь нь энэ сургалтыг бусад төлөөлөгчдөд санал болгоно гэжээ.

Төлөөлөгчдөд зориулсан сэдэвчилсэн сургалтын агуулгыг “ИТХ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ”, “ИТХ-аас гарах шийдвэрийн төсөлд хийх дүн шинжилгээ” сэдвийн хүрээнд боловсруулав.

ИТХ-ын төлөөлөгчдийн манлайлах ур чадвар нэмэгдэв. Нийслэлийн бүх дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид, 10 аймгийн сумдын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтыг эхний хагас жилд зохион байгуулснаар тэдний мэдлэг чадвар нэмэгдэж, манлайлан ажиллах урам зориг нь сэргэсэн. Сургалтын үр дүнд төлөөлөгчид чухам яагаад, ямар өөрчлөлтийг бий болгохоор сонгогдсоноо болон үүргээ хэрхэн үр нөлөөтэйгөөр хэрэгжүүлэх талаар эргэцүүлэн дүгнэж чадсан.

Манлайллын сургалтыг 10 аймгийн ИТХ хамтран санхүүжүүлж зохион байгуулсан бөгөөд энэ нь 2017 онд тус сургалтад хамрагдсан ИТХ-ын дарга нарын энэ сургалтыг сумдынхаа тэргүүлэгчдэд хүргэх хүсэл зоригтой нь холбоотойн зэрэгцээ төлөөлөгчдөө сургалтаар дамжуулан чадавхжуулахад аймгийн ИТХ санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагийн илрэл юм. /Хавсралт 3/

Эмэгтэй төлөөлөгчийн манлайллын сургалтын хөтөлбөр, агуулга өмнөхөөсөө бүрэн шинэчлэгдэж, зохион байгуулагдсанаар аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид тойргийн сонгогчидтойгоо илүү ойр ажиллах, оролцооны чиглэлийн хууль тогтоомжийг үр дүнтэй ашиглах, орон нутагт тулгамдсан асуудлыг тодорхойлох, шийдлийг олох, эдгээр зорилгын үүднээс бие биенээ дэмжиж хамтран ажиллах сэдэл, чадварыг олж авлаа. Тус сургалт явагдсанаас хойш удаагүй байгаа ч сургалтаас олж авсан мэдлэг чадвараа ажил үүрэгтээ хэрэгжүүлэх санал санаачлагууд гарч байна. Тухайлбал, Говь-Алтай аймгийн Алтай сумын ИТХ-ын дэргэд “Эмэгтэйчүүдийн манлайллын клуб” байгуулагдаж, 5-р сарын 31, 6-р сарын 1-нд Эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулжээ. Орон нутгийн зорилтот бүлгүүдийг дэмжих зорилгоор Сайн үйлсийн аян зохион байгуулж, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар сонсгол хийхээр төлөвлөж байна. Булган аймгийн Рашаант сумын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид өмнө нь намын харьяаллаасаа шалтгаалан хамтран ажилладаггүй байсан бол сургалтын дараа сумын эмэгтэйчүүдийн баярын хурал, арга хэмжээг хамтран зохион байгуулж, тус сургалтын агуулгыг танилцуулан, нийгмийн сайн сайхан орон нутгийн хөгжлийн төлөө эмэгтэйчүүд нэгдэж ажиллах талаар зөвлөлгөөн хийжээ. /Хавсралт 4/

Төслийн хүрээнд зохион байгуулсан эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалтыг сайн туршлага хэмээн онцолж, Улаанбаатар хотод 2018 оны 9 дүгээр сард болсон “Азийн улсуудын сайн засаглалыг бэхжүүлэх нь” олон улсын хуралд танилцуулга хийхийг урьсны дагуу сургалтын онцлог, арга зүй, гарч буй эхний үр дүнгүүд болон цаашид хийх үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж оролцов.

➤ **Сургагч багш нарын үндэсний сүлжээг дэмжих, хөгжүүлэх**

Төслийн хүрээнд бэлтгэгдсэн нийт сургагч багш нарын сургалт семинар энэ онд 2 удаа зохион байгуулагдсан. Сургагч багш нар 2017, 2018 онд төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт, багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарын сургалт, манлайллын сургалтад тодорхой сэдвээр хичээл зааж ажилласан. Үүнээс гадна сургалтын мөрөөр сум, багийн хуралд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалтаар олгогдсон мэдлэгийг бататган ажиллахад нь дэмжлэг үзүүлэх ажлыг сургагч багш нар сайн дурын үндсэн дээр хийж гүйцэтгэлээ. Тухайлбал, Баянхонгор аймгийн сургагч багш тэтгэлэг хэрэгжүүлж буй Богд сумын ИТХ-д хяналтын чиг үүргийн чиглэлээр сургалт явуулж, бодлогын баримт бичиг боловсруулахад нь зөвлөгөө өгсөн бол Орон нутгийн хөгжлийн сан ТББ-ын сургагч багш Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ИТХ-ын www.khural.mn дэд цахим хуудас, хуралдааны дэгд дүн шинжилгээ хийж, зөвлөмж өгчээ.

➤ **Төслийн дунд хугацааны үнэлгээ**

Олон улсын зөвлөхүүдийн баг төслийн дунд хугацааны үнэлгээг хийлээ. Тус үнэлгээний багт бие даасан зөвлөх Др.Чериан Жосеф /багийн ахлагч/, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн бүсийн төвийн зөвлөх Патрик Дуонг, Швейцарын хөгжлийн агентлагийн хөтөлбөрийн зохицуулагч Лилиан Тарнутцер нар ажилласан. Зөвлөхүүд УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын холбогдох ажилтнуудтай уулзаж, мэдээлэл, санал солилцов. Мөн Хан-Уул дүүрэг, Сэлэнгэ, Төв аймгуудад ажиллаж, ИТХ, ИНХ, иргэдийн төлөөлөлтэй уулзаж, төслийн хүрээнд хийгдэж буй үйл ажиллагааны үр дүн, цаашид анхаарах асуудлын талаар судаллаа. Үнэлгээний баг урьдчилсан тайландаа өнгөрсөн хоёр жилийн хугацаанд төслийн хэрэгжилт, үр дүн сайн байсныг дурдаад, дараагийн хоёр жилд төлөөллийн байгууллагын талаарх иргэдийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, ТББ-ын тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлэх, www.khural.mn цахим хуудасны тогтвортой байдлыг хангах зэрэг санал зөвлөмжийг тусгасан байна. /Хавсралт 5/

ХҮРЭХ ҮР ДҮН 4: Сонгогдсон Төлөөлөгчдөд дэмжлэг үзүүлэх УИХ-ын Тамгын газрын чадавх сайжирсан байх

Сонгогдсон төлөөлөгчдөд дэмжлэг үзүүлэх Улсын Их Хурлын Тамгын газрын (цаашид “Тамгын газар” гэх) чадавхыг сайжруулах чиглэлээр төслийн баримт бичиг болон 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд (i) хууль тогтоомжийн төсөл боловсруулах; (ii) хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хүний нөөцийн чадварыг хөгжүүлэх, харьцуулсан судалгаа шинжилгээний бүтээгдэхүүн гаргаж, практик хэрэглээнд нэвтрүүлэх, сургалт судалгааны эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Парламентын хуралдааны дэгийн асуудлаар анх удаа иж бүрэн дүн шинжилгээ хийлээ. Тус судалгаагаар парламентын бие даасан, хараат бус байдлын гол баталгаа болох УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, дэгээр зохицуулах асуудал бүрийн хүрээнд парламентат ёс өндөр түвшинд хөгжсөн гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсны үндсэн дээр дэгийн тухай хуулийг боловсронгуй болгох санал зөвлөмжийг боловсруулав.

Мөн түүнчлэн, зарим улсын парламентын хуралдааны дэгийг орчуулах ажлыг гүйцэтгэсэн нь хууль тогтоогчид болон эрдэмтэн, судлаач, практик ажилтнууд дэгийн онол практик, хөгжлийн хандлагын асуудлаар харьцуулсан судалгаа шинжилгээ хийх, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийг боловсронгуй болгох өргөн боломжийг нээж өгч байна.

Төслийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх арга зүй, технологийг нэвтрүүлэх, УИХ-ын Тамгын газрын хүний нөөцийн чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллалаа. УИХ-ын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 2018 оны 6 дугаар сард Улаанбаатар, 10 дугаар сард Швейцарын холбооны улсын Берн хотноо тус тус арга зүйн сургалт, хэлэлцүүлэг, харилцан туршлага солилцох арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэв. Хамтын ажиллагааны үр дүнд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж үр дүнг, УИХ-ын холбогдох Байнгын хороо, ажлын хэсэгт танилцуулсан бол Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийх ажлыг эхлүүлж, үнэлгээний дизайн (үнэлэх асуудал, зорилго, зорилт, арга зүй, зохион байгуулалт, тайлагнах гэх мэт)-ыг гаргаад байна.

ДҮГНЭЛТ

Нутгийн удирдлагатай холбоотой хууль, эрх зүйн шинэчлэлийг дэмжих үүднээс одоо үйлчилж буй хуулийн хэрэгжилтэд дүгнэлт хийж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналыг судлаачдын баг боловсруулснаас гадна бусад улс орнуудын сайн туршлагын талаар судлах, мэдээлэл олж авахад УИХ-ын ажлын хэсэгт туслалцаа үзүүлж, хамтран ажиллав.

ИТХ-ыг чадавхжуулах чиглэлээр төслийн хүрээнд бий болсон мэдлэг, мэдээлэл, хөтөлбөр, үйл ажиллагаа, түүний үр дүнг бэхжүүлэх, цаашид тогтвортой үргэлжлүүлэхэд аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нар анхаарал хандуулж, жишиг дэгийг нэвтрүүлэх, ажлын гүйцэтгэлийн багц үзүүлэлтийг боловсруулах, ажлын албыг чадавхжуулах сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөө гаргах зэрэг төслийн гол хүрэх үр дүнгийн чиглэлээр зургаан ажлын хэсэгт хуваагдан, төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллаж байна. Энэ нь сайн дурын үндсэн дээр явагдаж байгаа үйл ажиллагаа бөгөөд хурлууд хоорондоо мэдээлэл солилцох, харилцан суралцах, хамтын ажиллагаа хөгжүүлэх, нийтлэг эрх ашгийн төлөө нэгдэхэд түлхэц болж байгаа төдийгүй төслийн тогтвортой байдалд чухал хувь нэмэр оруулж байна.

ИТХ-ууд дангаараа болон төрийн бус байгууллагатай хамтран үйл ажиллагаагаа боловсронгуй болгох, шинэлэг арга барилаар ажиллаж турших, төлөвлөлт, хяналтад иргэдийг оролцуулах чиглэлээр санаачилга дэвшүүлэх, туршлагаа хуваалцахад төслийн хүрээнд зарладаг тэтгэлэгт хөтөлбөр чухал хувь нэмэр оруулж байна.

ИТХ-ын төлөөлөгчдийн манлайллын ур чадварыг нэмэгдүүлснээр орон нутгийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн санал санаачлагыг тусгах, тэдний эрх ашгийг хамгаалан ажиллах, тулгамдсан асуудлыг зөв тодорхойлон, шийдэл гарцыг олох чадавх сайжирч байна. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан сургалтын үр дүнд тэд намын харьяаллаас шалтгаалахгүйгээр орон нутгийнхаа хөгжил, иргэдийнхээ төлөө нэгдэн ажиллаж эхлээд байна.

Хууль тогтоох үйл явцыг илүү боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд дүн шинжилгээ хийх, гадаадын улс орнуудын парламентын хуралдааны дэгийг орчуулах цогц үйл ажиллагааг зохион байгуулав. Түүнчлэн УИХ-ын Тамгын газрын ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор гарын авлагууд боловсруулах, сургалт зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх арга, аргачлал, дүрэм, журам боловсруулах чиглэлээр Швейцарын парламентын Тамгын газартай харилцан туршлага солилцоход дэмжлэг үзүүлээд байна.

II ХЭСЭГ: ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

ХҮРЭХ ҮР ДҮН 1: Нутгийн удирдлагын эрх зүйн орчин сайжирсан байх

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч “Хууль судлалын төв” ТББ ажлын үр дүнгээ 2018 оны 5 дугаар сард ирүүлэв. Тус зөвлөх үйлчилгээний үр дүнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн эрх зүйн дүгнэлт болон нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал боловсруулагдсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Дөрөвдүгээр бүлэг, холбогдох бусад хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон улсын сайн туршлагыг судалсны үндсэн дээр оновчтой, үр дүнтэй байдлаар боловсруулах зорилгоор Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Лүндээжанцан тэргүүтэй төлөөлөгчид 2018 оны 3 дугаар сарын 18-23-нд Финланд Улсад, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт тэргүүтэй төлөөлөгчид 2018 оны 3 дугаар сарын 26-30-ны хооронд Япон Улсад ажиллалаа.

Үүний үр дүнд тухайн улсуудын засаг захиргааны нэгжүүдийн чиг үүргийн хуваарилалт, хотын эрх зүйн байдал, орон нутгийн төсөв, санхүүгийн зохицуулалт, төв Засгийн газрын түвшинд орон нутгийн асуудлыг хариуцан ажилладаг бүтэц тогтолцоо,

одоо явагдаж байгаа бодлогын өөрчлөлт зэрэг асуудлаарх эрх зүйн зохицуулалт, практикийг харьцуулан судалж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэх чиг үүрэг бүхий УИХ-ын Ажлын хэсгийн хэлэлцүүлэгт танилцуулж мэдээлсэн байна.

Тус үр дүнгийн хүрээнд нутгийн удирдлагатай холбоотой хууль тогтоомж болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээг эхлүүлээд байна. Энэхүү зөвлөх үйлчилгээний хүрээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөл, дагалдах хууль, тогтоолын төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгын саналыг боловсруулна. Түүнээс гадна хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийн, төслийг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хэлэлцүүлж саналыг авах цогц үйл ажиллагааг явуулна. Зөвлөх нь үйлчилгээг гүйцэтгэх явцдаа УИХ-ын Байнгын хороо, ажлын хэсэгтэй мэдээлэл солилцож, санал, зөвлөмжийг судалж, хамтран ажиллах юм.

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Швейцарын хөгжлийн агентлагийн “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төсөлтэй хамтран 2018 оны 10 дугаар сарын 23-нд Өмнөговь аймгийн Даланзадгад суманд говийн бүсийн хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэг нь төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг танилцуулах, хууль эрх зүйн орчны нэмэлт, өөрчлөлтийн талаар мэдээлэл хүргэн хэлэлцүүлж, санал авах зорилготой байв. Хэлэлцүүлэгт говийн бүсийн аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, газар, хэлтсийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнууд оролцож, нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналтай холбогдуулан өөрсдийн санал бодлоо хуваалцсан бөгөөд эдгээрийг төслийн хүрээнд боловсруулж байгаа нутгийн удирдлагатай холбоотой хуулийн төсөлд авч үзэх юм. Түүнчлэн Өвөрхангай аймагт болсон Хангайн бүсийн уулзалт-хэлэлцүүлэг, төслийн Сургагч багш нарын сургалт зэрэг төслийн хүрээнд зохиогдсон арга хэмжээний үеэр дээрх судалгааны үр дүнг танилцуулж, оролцогчдын саналыг авсан.

Нутгийн удирдлагын эрх зүйн зохицуулалт, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын үйл ажиллагааг илүү боловсронгуй болгоход энэ чиглэлийн онол, олон улсын сайн туршлагаас ашиглах боломжийг нэмэгдүүлэх үүднээс *“Муниципальное право зарубежных стран. Теория и современная практика”* (авторы Виталий Еремян, Дмитрий Ежевский, Е. Ешинимаева-Шагдарова, И. Кокорев, Леван Чихладзе, А. Чупанов, 2017) номыг орос хэлнээс монгол хэл рүү орчуулах зөвлөх үйлчилгээг зарлан хэрэгжүүллээ.

ХҮРЭХ ҮР ДҮН 2: ИТХ-ын зохион байгуулалтын чадавх сайжирсан байх.

➤ ИТХ-ын хяналт, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэх тэтгэлэг:

Өмнө тэтгэлэг хэрэгжүүлж байсан ИТХ-уудын сайн туршлагаас судлах, ирүүлж буй саналын чанарыг сайжруулах зорилгоор 2018 оны 1 дүгээр сард харилцан туршлага

солилцох уулзалт зохион байгуулав. Уг арга хэмжээнд 2014-2017 онд тэтгэлэг хэрэгжүүлсэн ИТХ-уудын төлөөлөл болон 2017 онд тэтгэлэг хэрэгжүүлсэн ТББ-ууд оролцож туршлага, арга зүй, сургамжаа ярилцаж, санал солилцсон.



Тэтгэлэгийн сайн туршлага солилцох уулзалт семинар 2018.01.31



Аймаг, дүүргийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын уулзалт 2018.01.29-30

ИТХ болон ТББ-ын ээлжит тэтгэлэгт хөтөлбөрийг 2018 оны 1 сард зарласны дагуу ИТХ-аас 81, ТББ-аас 23 санал ирсэн. УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар эдгээр саналыг үнэлж, шалгаруулах хороо байгуулагдан, санал тус бүртэй танилцсаны үндсэн дээр 39 ИТХ, 6 ТББ тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэв.

Энэ удаагийн ИТХ-ын сайн туршлагыг хөхиүлэн дэмжих зорилготой тэтгэлэгт хөтөлбөрийн онцлог нь хурлын хяналт, төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэх санал санаачлагыг дэмжихийн зэрэгцээ ШХА-ын “Ногоон алт” төсөлтэй хамтран бэлчээрийн менежементийн чиглэлээр боловсруулж ирүүлсэн 19 төсөлд тэтгэлэг олгосон.

“Ногоон алт” төслөөс төслийн чиг баримжаа олгох сургалтыг 2018 оны 5 дугаар сарын 14-ны өдөр Улаанбаатар хотод нийт 19 иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. ИТХ-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, санхүүжилтийн хуваарь, төслийн хэрэгжилтийн явцад үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэрхэн ирүүлэх талаар зөвлөмж зааварчилгаа өгч:

- малчдын хэсэг бүлгийн үйл ажиллагаа,
- бэлчээрийн ашиглалтын журам, төлөвлөгөөг хэрхэн боловсруулж хэрэгжүүлэх
- бэлчээр ашиглах гэрээний талаар үндсэн ойлголтуудыг өгөх,
- өмнө нь төсөл хэрэгжүүлсэн сайн туршлагаас хуваалцах зэрэг чиглэлээр сургалт хийжээ.

Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд аймаг, сумын хэмжээнд эрүүл мэнд, залуучуудын хөгжлийг дэмжих зэрэг дэд хөтөлбөр батлагдаж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд өөр өөрийн онцлог арга, аргачлалаар хяналт үнэлгээ хийгдэж, иргэдийн оролцоог хангах шинэлэг арга хэлбэрүүдийг туршив.

УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар тэтгэлэгт ИТХ, ТББ-ын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, явцын болон үр дүнгийн тайланг хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллав.

➤ **ИТХ-ын үйл ажиллагаанд хэрэглэх аргачлал, гарын авлага боловсруулж, нэвтрүүлэх:**

Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нарыг тал бүрийн мэдээллээр хангах, санал солилцох сургалт-семинарыг 2018 оны 1 сарын 29, 30-нд зохион байгуулсан. Семинарын үеэр тогтвортой хөгжлийн зорилтыг орон нутгийн төлөвлөлтөд тусгах, уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчны асуудлыг шийдвэрлэх, хурлаас хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах үйл ажиллагааг боловсронгуй болгох, иргэдийн оролцоог хангах болон хуралдааны дэгийн асуудлаар санал солилцож, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргав. Сургалт семинарт оролцсон нарийн бичгийн дарга нарын эдгээр сэдвээрх мэдлэг, ойлголт дээшилж, хэлэлцүүлэг өрнүүлэн санал солилцсоноор төслийн бүтээгдэхүүн, үр дүнг хуралд нэвтрүүлэх идэвх чармайлт, оролцоо нь идэвхжсэн.

Тус сургалт семинарын үр дүнд нарийн бичгийн дарга нараас бүрдсэн зургаан ажлын хэсэг байгуулагдсан. Нарийн бичгийн дарга нар өөрийн хамгийн сонирхож буй болон мэргэшсэн чиглэлээрх ажлын хэсэгтээ орсон бөгөөд жилийн ажлын төлөвлөгөө гарган ажиллав.

- ❖ ИТХ-ын хуралдааны жишиг дэгийг зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулсан бөгөөд нарийн бичгийн дарга нараас бүрдсэн ажлын хэсэг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын уулзалт, Сургагч багш нарын сургалтын үеэр хэлэлцүүлэн, тэдний саналыг авч тусгасан. Ажлын хэсгийн гишүүд Орхон аймагт 4 дүгээр сард уулзаж, жишиг/үлгэрчилсэн дэгийг заалт бүрээр ярилцаж, практикт элбэг тохиолддог асуудал бэрхшээлийн гарцыг тодорхойлох, буруу ойлгогдон хэвшсэн асуудлыг нэг мөр болгох зэргээр нэмэлт боловсруулалт хийв. Аймаг, сум, дүүргийн ИТХ-д тус үлгэрчилсэн дэгийг нэвтрүүлэх талаар судлан үзэхийг хүссэн албан бичгийг хүргүүлсэн.
- ❖ ИТХ-ын ажлын үр дүнг үнэлэх багц үзүүлэлтийн төслийг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээрх нарийн бичгийн дарга нарын Ажлын хэсэг 5 дугаар сард Улаанбаатар хотод уулзаж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох орчин үеийн чиг хандлага, Европын орнуудад хэрэгжүүлж буй туршлага, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, мэдээлэл цуглуулах талаар мэдээлэл сонсож, тодорхой ойлголттой болов. Зөвлөх үйлчилгээний хүрээнд ИТХ-ын гүйцэтгэлтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох ажил хийгдэж байна. Гүйцэтгэсэн ажлын эхний хувилбарыг ИТХ-ын дарга нар, ажлын хэсгийн гишүүдтэй хийсэн уулзалтын үеэр танилцуулж санал авав.

➤ **ИТХ-ын ажлын албыг чадавхжуулах, сайн туршлага солилцоход дэмжлэг үзүүлэх**

ИТХ-ын үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор хөгжиж буй улс орнуудын туршлагаас суралцахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд аймгийн ИТХ-ын дарга нар Польш, Филиппин Улсын нутгийн удирдлагын тогтолцоотой танилцаж, туршлага

судлав. Засаг захиргааны нэгжүүдийн чиг үүргийг тодорхой зааглах, орон нутагт татвар, өмчийн эрхийг олгох замаар санхүүгийн төвлөрлийг бууруулах, орон нутгийн төлөөллийн болон гүйцэтгэх засаглал хоорондын харилцааны тэнцвэрийг хангах зэрэг Польш Улсын сайн туршлагад үндэслэсэн саналыг нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж буй *УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, холбогдох ажлын хэсэгт хүргүүлэх төлөвлөгөөтэй байна.*


Аймгуудын ИТХ-ын өөрсдийн санаачлагаар нутгийн өөрөө удирдах байгууллагууд харилцан туршлага солилцох, харилцаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой бүсчилсэн хэлэлцүүлгүүд зохион байгуулагддаг уламжлал бий болсон байна. Энэхүү тогтсон механизмыг түшиглэн төслийн хүрээнд хамтран ажиллах боломжийг судлах талаар ИТХ-уудтай ярилцаж тохироод байна. Тухайлбал, 9 дүгээр сард Өвөрхангай аймагт болсон хангайн бүсийн уулзалт хэлэлцүүлэгт Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл аймгууд оролцож, аймгийн ИТХ-аас сум, багийн хуралд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог дэмжин ажиллах, багийн ИНХ-ын үйл ажиллагааг сайжруулах, хурлын байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулах, хяналтын үр нөлөөг дээшлүүлэх зэрэг үйл ажиллагааны талаар харилцан туршлага солилцов. Мөн нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаарх санал, зөвлөмжийг судлаач Н.Лувсанжав танилцуулав.

ХҮРЭХ ҮР ДҮН ГУРАВ: Орон нутгийн сонгогдсон Төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизмтай болох

Манлайллын сургалт: 2018 оны эхний хагаст нийслэлийн бүх дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид, 10 аймгийн сумдын тэргүүлэгчид хоёр өдрийн манлайллын сургалтад хамрагдаж, манлайлах ур чадвараа нэмэгдүүлэхийн зэрэгцээ бусдын манлайллын түүхээс суралцав. ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалтаас ялангуяа анх удаа сонгогдсон төлөөлөгчид төлөөлөгчийн эрх, үүрэг хариуцлагаа ухамсарлаж, эрх зүйн ойлголт мэдлэгтэй болсон бол манлайллын сургалтаас иргэдийн төлөөлөл болсон улс төрчийн хувьд хэрхэн алсын хараа, стратегитэйгээр бусдыг манлайлах, манлайллын түүхээ бүтээх талаар ур чадварт суралцлаа.



Дорнод аймгийн сумдын ИТХ-ын тэргүүлэгчдийн манлайллын сургалт, 2018.03.19-20



Чингэлтэй дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт, 2018.01.26-27



Багахангай дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт, 2018.03.15-16




Суурь сургалтаар олгогдсон мэдлэг чадварыг амьдралд хэрэгжүүлэхэд сонгогдсон төлөөлөгчийн хувиар хэрхэн манлайлж оролцох, нийгмийн хүсэн хүлээж

байгаа өөрчлөлтийг хийх, уг хүсэл эрмэлзлээ бусдад ойлгуулах, нөлөөлөх чадваруудыг хөгжүүлэх зорилготой Тэргүүлэгчдийн манлайлал сургалтын агуулгыг олон улсын зөвлөх боловсруулсан бөгөөд 2017 онд аймгийн ИТХ-ын дарга, тэргүүлэгчдэд хүргэсэн. “Төлөөлөгчийн манлайлал” сургалт нь улс төрийн манлайлал, хувийн манлайлал, стратегийн манлайлал, иргэдийг манлайлах гэсэн дөрвөн үндсэн сэдвээс бүрдсэн хоёр өдрийн сургалт юм. Энэ сургалтын хөтөлбөрөөс Төлөөлөгчид өнгөрсөн үеийн сорилт, ололтоосоо үнэт зүйлээ тодруулж, алсын хараагаа тодорхойлох, өөрийн зорилго, ажил үйлсийг бусдад ойлгуулах, тэдний дэмжлэгийг авахын тулд манлайллын цогц түүх бүтээх, ярих, орон нутагт тулгамдаж буй асуудлыг томоор буюу бүтэн зургаар харж, цогцоор шийдэх зэрэг манлайллын орчин үеийн шинэлэг онол хандлагад үйлдэн суралцах буюу интерактив аргаар суралцдаг.


Иргэд, олон нийтийг сонгогчид, мэдээлэл хүргэж, санал авдаг төдийхнөөр хардаг байсан ойлголт хандлагыг энэ сургалт өөрчилж чадсан. Иргэд, олон нийт бол нөөц, хүч, боломж юм байна, эерэг өөрчлөлт хийхэд миний хамтрагч юм байна, юм гэсэн агуулга, хандлагыг өгч чадсан. /Сургагч багшийн тайлангаас/

манлайллын сургалт	нийт төлөөлөгч, тэргүүлэгчийн тоо	үүнээс сургалтад оролцогсдын тоо	сургалтад хамрагдагсдын хувь
дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт	290	250	87.2%
сумдын ИТХ-ын тэргүүлэгчдийн сургалт	1215	1097	90.3%


Сургалтын дараах санал асуулгаар оролцогчдын сургалтаас олж авсан ойлголт мэдлэг, төлөөлөгчийн үүрэгтэй нь холбоо хамааралтай байдлыг тодорхойлохыг зорьсон бөгөөд сургалтын бодит үр дүнг тодорхой хугацааны дараа үнэлэх боломжтой болно. Санал асуулгад оролцогчдын 90 хувь нь сургалтын агуулга төлөөлөгчийн ажил үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг мэдээллийг өгсөн гэсэн бол 96 хувь нь сургалтын үр дүн хүлээлттэй нь нийцсэн гэжээ. Санал асуулгын дүн аймаг, дүүрэг, сумын хувьд ижил гарсан. Сургалтын чанарыг мөн өндрөөр үнэлсэн, тухайлбал, оролцогчдын 84-96 хувь нь сургагч багш нарын мэдлэг чадвар, жишээ тайлбар, харилцан суралцах, оролцоог хангаж байсан зэргийг маш сайн гэж үнэлсэн байна.



Оролцогчдын өөрийн үнэлгээнээс харахад дээрх манлайллын үндсэн дөрвөн сэдэв тус бүрт мэдлэг чадвараа ахиулсан гэжээ.



Эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалт: Сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн 28 хувь нь эмэгтэйчүүд бол аймгийн ИТХ-д эмэгтэйчүүдийн эзлэх хувь 15.7, нийслэлд 22.2 хувь байна.



Нийт 2100 гаруй эмэгтэй төлөөлөгчийн 59.8% нь анх удаагаа сонгогдсон шинэ төлөөлөгч байна. Иймд эдгээр төлөөлөгчдөд тус сургалтыг дахин явуулах¹ хэрэгцээ шаардлага байгааг төслийн баримт тодорхойлсон. Сургалтын агуулгыг шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, өмнө нь хийгдсэн сургалтын туршлага сургамж,

¹ Төслийн өмнөх үе шатанд эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалтыг 2014-2015 онд зохион байгуулсан.

оролцогчдын саналд үндэслэн дахин боловсруулах ажлыг “Монфемнет” ТББ гүйцэтгэсэн. Шинэчилсэн сургалт нь өмнөх сургалтад оролцсон төлөөлөгч эмэгтэйчүүдийн туршлагаас сэдэвлэсэн кейс судалгаа, жишээ, баримтаар баяжигдсан, шинэ агуулга бүхий сургалтын хөтөлбөр, гарын авлага болсон. Тухайлбал, ИТХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх, сонгогдсон эмэгтэй төлөөлөгчдийн улс төрийн бодит оролцоо, нөлөөллийг дээшлүүлэх, сонгуульд дахин өрсөлдөх, анхан шатнаас эхлээд дараагийн шатны буюу аймаг, нийслэлийн ИТХ-д сонгогдон ажиллах чадавхыг бэхжүүлэх зорилгоор хамтын манлайллын ур чадварууд болох 1) Тулгамдсан асуудлыг шинжлэх, шийдлийн боломжит хувилбарыг гаргах; 2) Оролцогч талуудыг тодорхойлох, шинжлэх; 3) Шийдвэр гаргагчдад нөлөөлөх; 4) Бусдыг сэдэлжүүлэх, үйл хэрэгтээ нэгтгэх; 5) Иргэдийн оролцооны шинэ хууль тогтоомжийг хэрэглэх стратеги, арга замыг санал болгосон агуулгыг түлхүү багтаасан байна.



Завхан аймгийн эмэгтэй Төлөөлөгчдийн сургалт, 2018.04.25-26



Ховд аймгийн эмэгтэй Төлөөлөгчдийн сургалт, 2018.02.26-27

Нийслэл, 9 дүүрэг, 21 аймгийн ИТХ-ын 2100 орчим эмэгтэй Төлөөлөгчийн 85,9 хувь нь сургалтад хамрагдсан. Мөн сумдын ИТХ-ын 200 гаруй эмэгтэй нарийн бичгийн дарга нар оролцов.

ИТХ	нийт эмэгтэй Төлөөлөгчийн тоо	сургалтад хамрагдсан	ирц хувиар
аймаг, сум	2070	1803	87.1
нийслэл, дүүрэг	92	55	59.8
нийт дүн	2162	1858	85.9

Сургалтын үеэр оролцогчдоос сургалтын өмнөх ба дараах асуулга авсны зэрэгцээ төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөлөл зарим сургалтад ажиллаж ажиглалт, ярилцлага хийх зэргээр хөндлөнгийн хяналт-үнэлгээ хийсэн.


Сургалт амжилттай явагдаж байна. Оролцогчдыг бүлгээр ажиллуулах явцад бэлтгэл сайн, холбогдох материал (төрийн болон орон нутгийн бодлогын баримт бичгүүд гэх мэт), зааварчилгаагаар сайн хангаж байсан. Танхимд хуваарилахдаа сумаар нь бүлэг болгон, нэг багш сургалтын туршид нэг бүлгийг чиглүүлэн ажиллаж байсан нь оролцогчид тулгамдсан асуудлаа хамтран тодорхойлж, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хамтран боловсруулахад үр дүнтэй арга болсон байна. Зөвхөн онол бус бодит амьдралд буй жишээ кейст үндэслэн мэдлэг олгож байсан бөгөөд эмэгтэй Төлөөлөгчид мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, маш идэвх сонирхолтойгоор сургалтад оролцож байв.



Сэлэнгэ аймгийн сургалтад хяналт үнэлгээ хийсэн Швейцарын хөгжлийн агентлагийн ажилтны тайлангаас

Сургалтын агуулгыг “Монфемнет” ТББ-ын сургагч багш нар оролцогчдод хүргэсэн. Оролцогчид тэдний заах арга зүйг дараах байдлаар үнэлжээ:







Сургалтын дараа хийсэн санал асуулгаас харахад эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын талаар ерөнхий ойлголт, нөлөөллийн аргыг ашиглаж асуудлыг хэрхэн шийдвэрлэх зэрэг ойлголт мэдлэг нь дээшилсэн гэжээ.





Төлөөлөгчид мэдлэг чадвараа дээшлүүлээд зогсохгүй зоригтой нэгдэх, дэвшүүлсэн санаа зорилгоо биелүүлэхээр санаачлагатай ажиллах, эмэгтэйчүүд бие биенээ дэмжиж ажиллах урам зориг төрсөн буюу төлөөлөгчийн ажил үүрэгтээ хандах хандлага нь өөрчлөгдсөн гэжээ.




- Манлайллыг өөрөөсөө эхлэхийг, сайн үр дагавар, бусдыг манлайлахын үнэ цэнийг ойлголоо

- Асуудлыг шинжилж, нэн тулгамдсан асуудлыг илрүүлэн шийдвэрлэх боломжит хувилбарыг гаргахад суралцлаа
 - Сургалтын дараа бүлэг байгуулан сумын хамгийн хүнд асуудал болох архидалтын эсрэг тэмцэхээр шийдсэн
 - Эрх мэдлийг бага гэлтгүй ажиллаж чадвал нийгэмд өөрчлөлт хийж чаддаг юм байна.
- Эмэгтэй төлөөлөгчдийн сэтгэгдэл, Сургалтын тайлангуудаас*

Бататгах, сэдэвчилсэн сургалт: Удирдлагын академитай байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд энэ онд суурь сургалтын үндсэн сэдвийн хүрээнд бататгах сургалтын агуулга; шинээр сэдэвчилсэн сургалтын агуулга бэлэн болов. ИТХ-ын Төлөөлөгчдийн нэгдсэн хуралдаанаар орон нутгийн төсвийн төсөл хэлэлцэхийн өмнө буюу 11 дүгээр сард “Орон нутгийн төсвийг төлөвлөх, хянахад ИТХ-ын гүйцэтгэх үүрэг” сэдэвт сургалтыг нийслэлийн дүүргүүдийн нийт Төлөөлөгчдөд зохион байгуулав.

Тус сургалтад дүүргийн төлөөлөгчдийн 63.8 хувь нь оролцов. Сургалтын үеэр хийсэн хяналт-үнэлгээний санал асуулгад нийт оролцогчдын 54.3 хувь нь буюу 88 хүн хамрагдсан. Судалгаанд оролцогчдын 98.9 хувь нь энэ удаагийн сургалт хэрэгцээтэй байсан гэж хариулсан байна. Мөн олонх Төлөөлөгчид ажил албандаа шаардлагатай мэдлэг, мэдээллийг сургалтаас олж авч чадсан бөгөөд энэ нь төсөв хэлэлцэх явцад эерэг өөрчлөлт авчирна гэжээ.



Сургалтын хөтөлбөр, агуулгын хувьд дараах байдлаар үнэлсэн байна:



Энэ сургалтыг бусад /аймаг, сумын/ ИТХ-ын Төлөөлөгчдөд санал болгоно гэж 81.2 хувь нь, магадгүй гэж 11.8 хувь нь хариулжээ.

Сургагч багш нарын сургалт: Төслийн хүрээнд бэлтгэгдсэн үндэсний сургагч багш нарын мэдлэг, чадавхыг дээшлүүлэх, төслийн үр дүнгийн тогтвортой байдлыг хангахад тэдний туслалцаа дэмжлэгийг авах, үүний тулд холбогдох мэдээ мэдээллээр хангахад анхааран ажиллаж байна. 2018 онд Сургагч багш нарын сургалтыг хоёр удаа зохион байгуулсан.

Дар

- Туурийн хуанрай гэр
 - баатар-гэвх олгодо, уншгад
 - Зуураагаар гэр, нуураар
муссаа, тус зуураагаар
 - баазад, хуанрайаа бүхний
хадгуунаа, алан туураагаар тэнгэр
муссаа, сүрхийн өмнөдөө
 - Золос-гүй илэн сүмтүгсэн
нуураагаа давааг дээр
 - хуанрай гэрээ зуураагаар
туурааг дээр, дэнд Золос-оор
- Ишиг гэр:
 - Ахуйга, - 2-жилаагтаа санаа
нуураагаа
 - Ахуйгаар хуанрайаа - Зуурааг



Сургагч багш нарын сургалт, Удирдлагын академи 2018.06.18-19

28

сургалтын үр дүнг үнэлэх арга зүй, төслийг системтэйгээр боловсруулах нь зэрэг мэдээллийг хүргэсэн.

Засаг захиргааны анхан шатны нэгж дээр очиж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх гэж буй санал ажил ач холбогдолтой байлаа. Багийн ИНХ-ыг дэмжин бэхжүүлэх, зөв голдролд үйл ажиллагааг нь оруулах хэрэгтэй учраас энэ сургалт үр дүнтэй байлаа. Сум бүр аймаг бүр дэгээ боловсруулахдаа өмнөх 4 жилүүдийнхээ дэгийг хуулж бичиж байгаад хурал нь гацаанаас гардаггүй. Оновчтой шийдвэр гаргадаггүй байдлыг нэг мөр болгох гэж байгаа нь сайшаалтай.
/Сургагч багийн санал, 2018.06.18-19-ний сургалтын үнэлгээнээс../

Сургалтад оролцсон ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар дээрх чиглэлээр мэдлэг, ойлголт дээшилж, төслийн дэмжлэгтэй боловсруулсан бүтээгдэхүүн, үр дүнг хуралд нэвтрүүлэх идэвх чармайлт, оролцоо идэвхжлээ гэж дүгнэжээ.

ХҮРЭХ ҮР ДҮН 4: Сонгогдсон Төлөөлөгчдөд дэмжлэг үзүүлэх УИХ-ын Тамгын газрын чадавх сайжирсан байх

- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх хүрээнд (a) тус хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх; (b) хуулийн холбогдох заалтуудыг гадаадын зарим улсын парламентын хуралдааны дэгийн заалттай харьцуулсан шинжилгээ хийх; (c) Монгол Улсын Их Хурлын тухай болон УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль хоорондын давхцал болон хийдлийг хуулийн системчлэлийн үүднээс шийдвэрлэх талаар санал боловсруулах; (d) парламентын хуралдааны дэгийн онол, зарчим, дэгээр зохицуулах зүйлд шинжилгээ хийж, зөвлөмж гаргах; (e) Үндсэн хуулийн цэцээс УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль Үндсэн хууль зөрчсөн талаар гаргасан дүгнэлтийг судалж, шинжилгээ хийх; (f) УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай **хуульд тусгах шаардлагатай асуудлууд буюу санал болгох зохицуулалтуудыг** тодорхойлов. УИХ-ын хууль тогтоох ажиллагааны журмыг үр нөлөөтэй, хариуцлагатай болгох, улмаар парламентын бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг боловсронгуй болгоход тус судалгааны үр дүнг ашиглах боломж бүрдсэн гэж үзэж байна.
- Зарим улсын парламентын хуралдааны дэгийг орчуулав. Төслийн хүрээнд ХБНГУ, ОХУ, БНСУ, Финланд (Үндсэн хууль болон парламентын хуралдааны дэг), Франц, Австрали, Канад зэрэг 7 улсын парламентын хуралдааны дэгийн орчуулгын ажлыг гүйцэтгэв. Дэгийн орчуулгыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр олон нийтийн хүртээл болгож судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах бөгөөд энэ нь хууль тогтоогч,



эрдэмтэн, судлаачид болон практик ажилтнуудад арга зүйн өндөр ач холбогдолтой судалгааны үндсэн эх сурвалж болж хэрэглэгдэх нөхцөл бүрдэнэ.

- Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу УИХ-ын Тамгын газар хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх шинэ чиг үүрэгтэй болсон бөгөөд энэ чиглэлээр Тамгын газрын ажилтнуудын чадварыг хөгжүүлэх зорилгоор Швейцарын парламентын Тамгын газартай харилцан туршлага солилцох, тэдний практикаас суралцах ажлыг 2017 онд эхлүүлсэн. Энэ онд хамтын ажиллагааг үргэлжүүлж, УИХ-ын Тамгын газраас сонгон авсан Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд хамтран ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор УИХ-ын Тамгын газар болон Швейцарын парламентын төлөөлөгчид 2018 оны 6 дугаар сарын 4-8-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо хамтарсан сургалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. /Хавсралт 6/



*УИХ-ын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газар ажилтнуудын уулзалт, семинар
Улаанбаатар хот, 2018.06.04-08)*

Сургалт хэлэлцүүлгээр дээр дурдсан хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх судалгааны асуулга, шалгуур үзүүлэлт, үнэлгээний загвар, арга ба хэрэглэгдэхүүнийг тодорхойлов. Сургалт хэлэлцүүлэгт оролцогчид бүлгээр ажиллаж хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх талаар сурч мэдсэн зүйлээ практикт хэрхэн хэрэглэх талаар дадлага ажил (Газар өмчлүүлэх тухай хууль) хийж, мэдлэгээ бататгасан. Сэдвийн дүгнэлт буюу асуулт, хариултын үеэр дадлага ажлыг хийхэд тулгарсан асуудлууд, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар оролцогчид харилцан бие биеэсээ суралцсан нь сонирхолтой, тэднийг илүү нээлттэй үзэл бодлоо илэрхийлэх боломжийг олгов. УИХ-ын Тамгын газрын ажилтнуудын өмнө нь хийсэн үнэлгээ (Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ) нь өөрсдийн өмнөх туршлагаа эргэцүүлэх, үнэлгээ хийхэд тулгардаг бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам зэрэг асуудлаар шинэ практикт суралцахад чухал ач холбогдолтой байлаа.

Сургалт хэлэлцүүлэгт оролцогчдын суралцсан зүйл: i) үнэлгээ хийх асуудлыг оновчтой тодорхойлох болон хууль тогтоомжийн тодорхой нэг эсхүл цөөн тооны зохицуулалтыг хамруулах хэрэгцээ шаардлага; ii) үнэлгээг захиалах болон үнэлгээ хийх үйл явцыг уялдуулах (асуулга, асуумж, арга, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох ба эдгээрийг хийсний дараа мэдээлэл цуглуулах); iii) нэр томьёо (хяналт-

шинжилгээний тодорхойлолт, хүчин зүйлс, хэмжүүр болон шалгуур үзүүлэлтийн ялгаа, тоон болон чанарын мэдээлэл); iv) шинжлэх ухаанч хандлагыг чухалчлах ба хариулах, мэдээлэл авахад хялбар, ойлгомжтой байх шаардлагыг харгалзан арга зүйг сонгох; v) чанарын шаардлагад нийцсэн үнэлгээ хийхэд хүрэлцэхүйц хугацаа тогтоох; vi) мэдээлэл цуглуулах арга техникийн хувьд итгэлцлийг бий болгох, ярилцлагыг амжилттай явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байх; vii) мэдээлэл цуглуулах, түүний үйл явцад хяналт тавих Засгийн газрын үүрэг, энэ үйл явц (санаачлах, тайлагнах үе шат) дахь УИХ-ын гишүүд/ холбогдох Байнгын хорооны оролцоо, үнэлгээний чиглэлийг сонгох (санаачлах ба үнэлгээний зүйлийг тодорхойлох); viii) үнэлгээ хийх ажилтнуудын ажил үүргийг хуваарилах, гэрээт ажилтны оролцоо, тайлан боловсруулах, хэвлэн нийтлэх гэх мэт.

“Сургалт, хэлэлцүүлэг маш их бүтээлч болж өнгөрлөө. Бид хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх нь хууль тогтоох үйл ажиллагаа бус жинхэнэ судалгааны ажил болох талаар олон зүйлийг сурч мэдлээ.”

“Сургалт, хэлэлцүүлэг маш сонирхолтой байсан бөгөөд хичээлийн хүрээнд гарсан асуултууд, шалгуур үзүүлэлт, хэмжүүрүүдийг өөрийн ажилдаа хэрэглэх боломжтой байсан.”

Сургалт, хэлэлцүүлэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх шинэ арга, аргачлалыг танилцуулсан маш үр дүнтэй, “нүд нээсэн” үйл ажиллагаа байлаа. Бид Засгийн газраас одоо баримталж буй үнэлгээний арга, хэлбэрийн хүрээнд “хайрцаглагдсан” буюу өмнө нь энэ талаар талаар маш бага ойлголт, мэдлэгтэй байжээ.

Сургалт хэлэлцүүлэгт УИХ-ын Тамгын газраас оролцогчид, 2018.06.08

Сургалт, хэлэлцүүлгийн явцад үнэлгээний тогтсон арга хэлбэрийг ягштал, хатуу баримтлах хандлагыг залруулах шаардлагатай талаар санал нэгдэв. Хамтран ажиллагч талууд үнэлгээний хамгийн сүүлийн үеийн онол, практикийн чиг хандлага, шинжлэх ухаанд суурилсан үнэлгээний стандартыг нэвтрүүлэх талаар харилцан мэдлэг, туршлагаа солилцлоо. Мөн түүнчлэн, Швейцарын парламентын Тамгын газартай ойр холбоотой хамтран ажиллах, сургалт, хэлэлцүүлгээр хөндсөн асуудлаас илүү өргөн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд албан ёсоор хамтран ажиллах талаар санал нэгдэв. Жилд хийх үнэлгээний тоог багасгаж, бодитой төлөвлөх, үнэлгээний үйл явцад УИХ-ын гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх асуудлыг ярилцсан.

- “Парламентын хяналт: Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг боловсронгуй болгох асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Төрийн ордонд зохион байгууллаа.²

² Монгол хэл дээрх хэвлэлийн мэдээ: <http://parliament.mn/n/upiy> <http://www.mnb.mn/i/144205>
<http://news.gogo.mn/r/226589>

Тус хуралд УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газар, Засгийн газар, олон улсын байгууллагууд, хувийн хэвшил болон бусад салбарын нийт 80 орчим төлөөлөл оролцов. Хурлыг УИХ-ын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Лүндээжанцан, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон, Швейцарын хөгжлийн агентлагийн Монгол Улс дахь суурин төлөөлөгч, Ерөнхий консул Габриела Спирли нар нээж, УИХ-ын гишүүн С.Бямбацогт, УИХ-ын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэгт, Швейцарын Парламентын Тамгын газрын Үнэлгээний нэгжийн дарга Николас Грожан, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн, Удирдлагын академийн багш А.Алтанзул, УИХ-ын Тамгын газрын зөвлөх Д.Зүмбэрэллхам нар илтгэл хэлэлцүүлэв.



*“Парламентын хяналт: хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг боловсронгуй болгох асуудал” сэдэвт Эрдэм шинжилгээний хурал
Төрийн ордон, 2018.06.08*

Хуралд оролцогчид илтгэлтэй холбогдуулан дараах саналуудыг онцлон тэмдэглэв: i) хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрх, бүтэц ба Хяналтын хороо³-нд дэмжлэг үзүүлэх бүтэц, түүний хараат бус байдал; ii) яамд хоорондын уялдаа холбоо, үүрэг хариуцлага; iii) иргэний нийгмийн төлөөлөл (УИХ-аас иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах, хариу өгөх / Өргөдлийн байнгын хороо) болон төрийн бус байгууллагуудтай хяналт шинжилгээ, үнэлгээний хүрээнд хамтран ажиллах; iv) Парламентын хууль тогтоох үйл ажиллагаанд тулгарч буй сорилтуудыг даван туулах нь түүний өөрийнх нь үндсэн чиг үүрэг; v) зарим нэр томъёоны (assessment, evaluation, monitoring, control, oversight) Монгол хэл дээрх орчуулгыг нэг мөр болгож жигдлэх; vi) парламентын хяналтыг сайжруулах, гэхдээ УИХ-ын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 500 гаруй хуульд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нь бэрхшээлтэй асуудал болохыг онцлов. Швейцарын парламентын Тамгын газрын төлөөлөгч илтгэлдээ Швейцарт хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх нь Засгийн газрын үүрэг байдаг талаар мэдээлэв. Хурлаас цаашид хэрэгжүүлж болох олон санаа дэвшүүлсний зэрэгцээ парламентын хяналтын ач холбогдлын талаар УИХ, Засгийн газар, эрдэм шинжилгээний байгууллага болон иргэний нийгмийн төлөөллүүд өндөр дээд түвшинд харилцан санал бодлоо солилцож, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх боломжийг бүрдүүллээ.

³ Швейцарийн парламент хяналтын чиг үүргээ Хяналтын хороогоор дамжуулан хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь тусдаа Байнгын хороо юм. Монгол Улсад ийм хороо байдаггүй.

Хэрэгжүүлж буй үйл ажиллагаа:

- Хуулийн төслийн эх барьж ажиллах УИХ-ын Тамгын газрын зөвлөх болон хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажилладаг бусад ажилтнуудад зориулсан **сургалтын хөтөлбөр, каталогийг** боловсруулж байна. /Хавсралт 7/



Сургалтын хөтөлбөр нь УИХ-ын Тамгын газрын зөвлөх болон бусад ажилтан(референт, шинжээч, бие төлөөлөгч-туслах г.м)-ы хууль тогтоомжид заасан үндсэн чиг үүргээ бүтээмжтэй, үр нөлөөтэй, хариуцлагатай хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадварыг эзэмшүүлэх болон сургалтын менежментийн тулгуур асуудлуудыг (арга зүй, сургагч багш, үнэлгээ, зохион байгуулалт г.м) тодорхойлсноороо онцлог юм.

Мөн “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд бий болох гарын авлага, судалгааны шинжилгээний бүтээгдэхүүнийг сургалтын хөтөлбөрийн агуулгатай интеграцчлах (уялдуулах) ажлыг хийв. Өөрөөр хэлбэл, төслийн

хүрээнд боловсруулж буй Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон нийтийн, хувийн эрх зүйд хамаарах салбарын хуулийн төсөл боловсруулах гарын авлага, хуулийн төсөл боловсруулагчийн ширээний ном (орчуулгын бүтээгдэхүүн), 7 улс орны парламентын хуралдааны дэг (орчуулгын бүтээгдэхүүн), парламентын хуралдааны дэгийн харьцуулсан судалгаа зэрэг нь УИХ-ын Тамгын газрын зөвлөх, ажилтны сургалтын практикт нэвтэрч, байнга хэрэглэгдэх эх сурвалж болох нөхцөл бүрдэж байна.

Сургалтын хөтөлбөрийн чанар, практик ач холбогдлыг сайжруулахын тулд зөвлөх үйлчилгээний явцад туршилтын сургалт явуулав. Энэ хүрээнд “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах арга зүйн зарим асуудал” сэдэвт сургалтыг 2018 оны 11 сарын 19-ны өдөр зохион байгуулж, Байнгын хороодын ахлах зөвлөх, зөвлөх зэрэг 30 хүн оролцлоо. Тус сургалтаар хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийх, хууль зүйн нэр томьёо, хэрэглээнд анхаарах асуудлуудыг авч үзэв. /Хавсралт 8/

- Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад ашиглах эх сурвалжаар хангах хүрээнд “The Legislative Drafters deskbook: A practical guide” номын орчуулах ажлыг гүйцэтгэж байна. Бүтээл нь хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны арга зүй, онцлогтой холбоотой өргөн агуулгын хүрээнд онолын суурь ойлголт, практик зөвлөмжүүдийг агуулснаараа хуулийн төсөл боловсруулагчдад (хууль тогтоогчид, хууль тогтоох байгууллагын ажилтан, эрдэмтэн, судлаачид гэх мэт) чухал ач холбогдолтой юм.

- Мөн төслийн хүрээнд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон нийтийн, хувийн эрх зүйд хамаарах салбарын хуулийн төсөл боловсруулах гарын авлагыг бэлтгэж байна. Эдгээр гарын авлагууд нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах хүрээнд зөвлөхүүд мэдлэг эзэмшсэн байвал зохих эрх зүйн онол, практикийн чиг хандлага, гадаад улсын болон үндэсний эрх зүйн тогтолцоонд тулгарч буй сорилт, түүнийг шийдвэрлэх арга зам, сайн туршлагыг нэгтгэнэ.
- Нийтийн сонсголын хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах УИХ болон УИХ-ын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Бүгд Найрамдахчуудын Олон улсын хүрээлэн (БНОУХ)-тэй хамтран “Нийтийн сонсголыг үр дүнтэй зохион байгуулах нь” сэдэвт сургалт, туршлага судлах үйл ажиллагааг 2018 оны 12 дугаар сарын 10-19-ний хооронд Улаанбаатар болон Сөүл хотноо зохион байгуулав. Энэ арга хэмжээ нь нийтийн сонсголын эрх зүйн зохицуулалт, тулгарч буй сорилт, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, энэ талаарх АНУ болон БНСУ-ын сайн туршлагаас суралцах зэргээр нийтийн сонсгол зохион байгуулах чиглэлээр хууль тогтоогчид болон УИХ-ын Тамгын газрын зөвлөх, ажилтнуудыг чадавхжуулахад чиглэв.
- ТББХ-ны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар бодлогын судалгаа хийхэд дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Энэ хүрээнд “Парламентын хяналтыг боловсронгуй болгох нь” сэдэвт бодлогын судалгааны ажлыг эхлүүлэв.
- Уг судалгаагаар парламентын хяналтын суурь үзэл баримтлал, хөгжлийн хандлага, Монгол Улс дахь парламентын хяналтын өнөөгийн байдал, гадаадын орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсны үндсэн дээр Монгол Улсын Их Хурлын хяналтын чиг үүргийг боловсронгуй болгох санал, зөвлөмжийг боловсруулахаар ажиллаж байна.

--ooOOoo--

Хавсралт

Хавсралт 1: Тэтгэлэг хэрэгжүүлж буй ИТХ, ТББ-ууд

Хавсралт 2: Дүүргийн төлөөлөгчдөд зориулсан бататгах сургалт

Хавсралт 3: Манлайллын сургалтын хуваарь, ирц, хөтөлбөр

Хавсралт 4: Эмэгтэй төлөөлөгчдийн манлайлал сургалтын хуваарь, ирц, хөтөлбөр

Хавсралт 5: Төслийн дунд хугацааны үнэлгээний тайлан

Хавсралт 6: УИХ-ын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газрын хамтын ажиллагааны төлөвлөгөө

Хавсралт 7: УИХ-ын Тамгын газрын зөвлөх, ажилтны сургалтын хөтөлбөр

Хавсралт 8: “Парламентын хяналт: хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг боловсронгуй болгох асуудал” эрдэм шинжилгээний хурлын хөтөлбөр